



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Ховд Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/01/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Д.Нарантуул
Утас: 99019800
цахим хаяг: narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	
3.5.1 Төсвийн төлөвлөлт	
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	
3.5.3 Нэмэлт төсөв	
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл	
4.2 Материаллаг байдал	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.5.1 Завсрын аудитын талаар	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	
Товчилсон үгийн жагсаалт	
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИНД	Иргэний нисэхийн дүрэм
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД НИСЭХ БУУДЛЫН ДАРГА
Б.БОЛОРЦЭЦЭГ ТАНАА

2023.03.06 № 2/101
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд аймаг дахь "Ховд" Нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймаг дахь "Ховд" Нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор "Ховд" нисэх буудал нь Хүннү Эйр ХХК, Аэромонголиа ХХК, Геосан, зэвсэгт хүчний 303 ангийн нийт 143 нислэгийн 79883 кг ачаа тээш, 6кг шуудан 5281 зорчигчид аюулгүй байдлын үзлэг хийж зорчигчоос агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон 457ш эд зүйлс илрүүлж зохих журмын дагуу бүртгэл хөтлөн, нислэгийн аюулгүй байдлыг бүрэн ханган ИНЕГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу "Ховд" Нисэх буудлын барилгад 223.9 сая төгрөгийн их засвар хийгджээ.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор Ховд аймагт анх удаа ОХУ болон агаарын цэргийн 337-р ангитай хамтран байлдааны бүрэн хэмжээний СЭЛЭНГЭ-2022 сургуулилт, 2022 оны 07 дугаар сарын 23-28-ны хооронд ОХУ-ын МИ8-8, МИ171-1, М26-6 нийт 15 агаарын хөлөгт газрын болон аэро навигацийн үйлчилгээг амжилттай үзүүлсэн байна.

021020351

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар буудал нь тайлант онд 8 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 90.3 хувийн биелэлттэй гэж дүгнэн ИНЕГ-т хүргүүлсэн байна.

ИНЕГ-ын даргын зөвлөлийн хурлын 2022 оны 12 тоот шийдвэрээр агаарын зайн өнгөрөлтийн нислэг, хураамжийн орлого буурах, хуваарьт нислэг багассан нь эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэнтэй холбоотой Булган сумын нисэх буудлын үйл ажиллагаанд сул зогсолт хэсэгчлэн зарласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>206,017,727.96</u>	<u>223,541,514.85</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	37,238,751.01	21,583,881.52
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	37,238,751.01	21,583,881.52
3121	Төгрөг	37,238,751.01	21,583,881.52
31213	Арилжааны банк дахь харилцах	37,238,751.01	21,583,881.52
33	АВЛАГА	2,643,322.22	13,034,841.99
33401	Дансны авлага /ТӨҮГ/	2,273,022.81	12,595,723.78
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	370,299.41	226,800.00
335	Бусад авлага	-	212,318.21
3351	Байгууллагаас авах авлага		84,545.46
3352	Хувь хүмүүсээс авах авлага		127,772.75
35	БАРАА МАТЕРИАЛ	166,135,654.73	188,922,791.34
354	Хангамжийн материал	166,135,654.73	188,922,791.34
35420	Аж ахуйн материал	110,327,010.22	103,779,545.65
35440	Түлш, шатах тослох материал	47,596,194.32	62,499,132.33
35470	Бусад хангамжийн материал	8,212,450.19	22,644,113.36
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,210,876,831.37</u>	<u>16,886,293,621.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,210,876,831.37	16,886,293,621.60
392	Биет хөрөнгө	1,947,923,830.66	3,589,247,679.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,411,461,187.78	4,832,492,992.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,411,347,726.11)	(3,501,925,625.43)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	839,623,820.00	879,239,337.46
39204	Хуримтлагдсан элэгдэл	(497,922,074.40)	(475,520,903.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,580,203,150.01	4,973,833,659.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,002,116,847.95)	(3,164,947,373.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,656,369.96	92,698,003.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,246,519.03)	(70,965,087.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,108,426.12	70,212,463.56
39215	Хуримтлагдсан элэгдэл	(46,495,955.72)	(45,869,787.86)
393	Биет бус хөрөнгө	13,262,953,000.71	13,297,045,942.36
39301	Программ хангамж	73,073,929.08	107,573,929.08
39302	Хуримтлагдсан элэгдэл	(70,018,928.37)	(70,425,986.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,259,898,000	13,259,898,000
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	16,695,000	51,795,479.45
39404	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/	16,695,000	51,795,479.45
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>15,433,589,559.33</u>	<u>17,161,630,615.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	480,654.05	37,505.26
413	Өглөг	480,654.05	37,505.26
4136	Бусад өглөг	480,654.05	37,505.26
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	37,505.26

41363	Татварын өглөг /ТӨҮГ/	64,320.59	
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	416,333.46	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>15,433,108,905.28</u>	<u>17,161,593,110.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	15,433,108,905.28	17,161,593,110.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	13,316,428,264.94	13,294,548,965.64
51101	Өмч: - төрийн	13,259,898,000	13,259,898,000
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	56,530,264.94	34,650,965.64
512	Хуримтлагдсан үр дүн	1,503,517,953.99	2,148,887,392.43
51210	Өмнөх үеийн үр дүн	-	1,503,517,953.99
51220	Тайлант үеийн үр дүн	1,503,517,953.99	645,369,438.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	613,162,686.35	1,718,156,752.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>15,433,589,559.33</u>	<u>17,161,630,615.90</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,247,367,791.30	2,545,093,999.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	243,956,723.81	945,942,765.34
120	Нийтлэг татварын бус орлого	56,656,899.32	942,376,104.28
120007	Навигацийн орлого	35,571,563.03	53,677,773.06
120009	Бусад орлого	1,000,000	3,893,620.30
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	20,085,336.29	884,804,710.92
121	Хөрөнгийн орлого	187,299,824.49	3,566,661.06
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	187,299,824.49	3,566,661.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,003,411,067.49	1,599,151,234.04
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,003,411,067.49	1,599,151,234.04
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,003,411,067.49	1,599,151,234.04
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,102,222,797.49	1,899,724,560.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,102,222,797.49	1,899,724,560.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,092,081,797.49	1,890,147,286.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,119,967,535.78	1,036,481,673.34
210101	Үндсэн цалин	685,570,751.93	523,550,317.30
210102	Нэмэгдэл	268,691,783.85	177,088,536.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	165,705,000	154,912,500
210104	Урамшуулал		180,930,319.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,077,066.75	139,904,074.04
210201	Тэтгэврийн даатгал	101,078,689.98	88,894,610.83
210202	Тэтгэмжийн даатгал	11,199,675.35	10,458,189.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,159,415.64	18,764,261.23
210204	Ажилгүйдлийн даатгал	2,239,935.07	1,980,637.35
210205	Эрүүл мэндийн даатгал	22,399,350.71	19,806,375.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,918,387.82	74,747,370.87

210301	Гэрэл, цахилгаан	30,794,248.17	27,104,761.17
210302	Түлш, халаалт	66,143,639.65	46,066,518.79
210303	Цэвэр, бохир ус	1,980,500.00	1,576,090.91
2104	Хангамж, бараа материалын зардал	180,014,515.88	194,626,006.13
210401	Бичиг хэрэг	4,786,430.27	1,924,611.56
210402	Тээвэр, шатахуун	96,259,199.69	95,433,668.79
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,895,729.01	7,431,186.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,286,849.58	7,146,763.31
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	490,727.28
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	65,786,307.33	82,199,049.18
2105	Нормативт зардал	16,713,818.18	9,563,632.18
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,713,818.18	9,563,632.18
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	136,663,633.14	22,732,179.33
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	19,166,282.77	7,601,873.04
210604	Урсгал засвар	117,497,350.37	15,130,306.29
2107	Томилолт, зочны зардал	47,167,505.52	47,167,505.52
210702	Дотоод албан томилолт	47,167,505.52	33,993,100
210703	Харуул хамгаалалт		945,468.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,247,424.81	119,798,096.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,163,000	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		600,000
210803	Даатгалын үйлчилгээ		7,280,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар		428,480
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ/ үл хөдлөх/		33,010,531.24
210807	Газрын төлбөр		21,228,198
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	113,560	120,700
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	64,161,364.90	57,130,187.09
210813	Бусад зардал /ТӨҮГ/	31,809,499.91	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	237,311,909.61	245,126,748.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,657,940.08	2,198,273.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000	1,474,090.81
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	231,153,969.53	241,454,384.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,141,000	9,577,274.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,141,000	9,577,274.38
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,141,000	9,577,274.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>145,144,993.81</u>	<u>645,369,438.44</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>145,144,993.81</u>	<u>645,369,438.44</u>

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(сая.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	-------	--

C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,259,898,000	613,162,686.35	1,358,382,960.18		15,231,443,646.53
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,259,898,000	613,162,686.35	1,358,372,960.18	78,409,564.24	15,309,843,210.77
C07	Тайлант үеийн үр дүн			145,144,993.81	(21,879,299.30)	123,265,694.51
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,259,898,000	613,162,686.35	1,503,517,953.99	56,530,264.94	15,433,108,905.28
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,259,898,000	613,162,686.35	1,503,517,953.99	56,530,264.94	15,433,108,905.28
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,259,898,000	613,162,686.35	1,503,517,953.99	56,530,264.94	15,433,108,905.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		1,104,994,066.22		-	1,104,994,066.22
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				(21,879,299.30)	-21,879,299.30
D08	Тайлант үеийн үр дүн			645,369,438.44	-	645,369,438.44
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,259,898,000	1,718,156,752.57	2,148,887,392.43	34,650,965.64	17,161,593,110.64

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,953,197,650.16</u>	<u>1,602,433,382.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,006,546.16	16,443,382.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,006,546.16	16,443,382.00
120007	Навигацийн орлого		10,005,000
120009	Бусад орлого	9,470,398	6,438,382
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	2,536,148.16	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,941,191,104	1,585,990,000
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,941,191,104	1,585,990,000
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,941,191,104	1,585,990,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,949,512,590.89</u>	<u>1,618,088,251.49</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,949,512,590.89	1,618,088,251.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,937,546,818.09	1,608,510,977.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,119,967,535.78	1,044,165,194.46
210101	Үндсэн цалин	685,570,751.93	531,233,838.42
210102	Нэмэгдэл	268,691,783.85	177,088,536.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	165,705,000	154,912,500
210104	Урамшуулал		180,930,319.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,077,066.75	130,751,092.11
210201	Тэтгэврийн даатгал	101,078,689.98	79,741,628.90

210202	Тэтгэмжийн даатгал	11,199,675.35	10,458,189.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,159,415.64	18,764,261.23
210204	Ажилгүйдлийн даатгал	2,239,935.07	1,980,637.35
210205	Эрүүл мэндийн даатгал	22,399,350.71	19,806,375.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,620,844.40	97,775,237.29
210301	Гэрэл, цахилгаан	33,727,344.40	29,815,237.29
210302	Түлш, халаалт	79,991,050	66,352,000
210303	Цэвэр, бохир ус	1,902,450	1,608,000
2104	Хангамж, бараа материалын зардал	141,096,860.03	117,920,801.01
210401	Бичиг хэрэг	6,560,250	2,578,290
210402	Тээвэр, шатахуун	107,870,000	102,669,228
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,658,316.03	7,687,203.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,338,800	3,766,080
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,669,494	1,220,000
2105	Нормативт зардал	13,440,000	10,520,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,440,000	10,520,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	169,440,965.89	104,550,493
210601	Багаж, техник, хэрэгсэл	82,311,055.76	85,497,059
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,295,870	10,936,084
210604	Урсгал засвар	65,834,040.13	8,117,350
2107	Томилолт, зочны зардал	31,312,500	33,993,100
210702	Дотоод албан томилолт	31,312,500	33,993,100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	182,915,556.24	64,256,925.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,163,000	1,629,016
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,100,000	600,000
210803	Даатгалын үйлчилгээ	7,279,000	7,280,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	565,725	428,480
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	319,000	
210806	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	33,010,531.24	33,010,531.24
210807	Газрын төлбөр	21,228,198	21,228,198
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	113,560	80,700
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	116,136,542	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,675,489	4,578,134
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,175,489	3,143,134
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000	1,435,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,965,772.80	9,577,274.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,965,772.80	9,577,274.38
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,965,772.80	9,577,274.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,685,059.27	(15,654,869.49)

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,685,059.27	(15,654,869.49)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,553,691.74	37,238,751.01
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,238,751.01	21,583,881.52

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ИНЕГ-ын харьяа Ховд аймаг дахь “Ховд” Нисэх буудал нь иргэний нисэхийн багц дүрмийн хүрээнд эрхэлж буй үйлчилгээ, үйл ажиллагааны бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, аэродром болон агаарын навигацийн үйлчилгээний болон нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг шаардлагад нийцсэн нислэг, хөдөлгөөн, аэродромын тоноглол, дохиолол, тэмдэгтүүдийг стандартын шаардлагад нийцүүлэн байнгын бэлэн байдлыг хангах, орон нутгийн нислэгийн мэдээллийг холбогдох байгууллага, удирдлагад дамжуулах гэсэн үндсэн чиг үүрэгтэй.

Нисэх буудал нь 2022 онд “Зорчигч, үйлчилгээ, нисэхийн аюулгүй байдлыг хангаж ажиллах” гэсэн эрхэм зорилтыг дэвшүүлэн нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Ерөнхий газрын даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх гэсэн үүрэг даалгаврыг ханган ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Ховд” Нисэх буудал нь Иргэний нисэхийн тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, болон хууль тогтоомж, ИНД-139, ИНД-140, ИНД-144, ИНД-171, ИНД-175 дүрмүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тайлант онд ИНЕГ-ын харьяа Ховд нисэх буудлын үйл ажиллагаандаа мөрддөг хууль, тогтоомжуудад өөрчлөлт ороогүй, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын А/93 тоот тушаалаар “Төрийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” батлагдсан, ИНЕГ-ын Иргэний нисэхийн Үндэсний төвийн газрын даргын А/38 тоот тушаалаар Ховд аймаг дахь “Ховд” Нисэх буудлын журам”, “Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн батлах тухай” А/05 тоот, бичиг хэргийн норм нормативыг А/103 тоот тушаалаар тус тус өөрчлөгдсөн байна.

Тайлант хугацаанд компани/ТӨҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. ИНЕГ-ын дотоод аудитын албанаас 2022 онд Ховд аймгийн “Ховд” нисэх буудлын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тус буудлын даргын тушаалаар аюулгүй ажиллагаа, дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнийг томилон гамшгаас хамгаалах, гал унтраах, галын дохиололтой холбоотой асуудлаар хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Ховд” нисэх буудал нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ховд Нисэх буудал нь ИНЕГ-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 21-ний А/124 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус ТӨҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Ховд Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,728.5 сая төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая. төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	37.2	21.6	(15.6)
Авлага	2.6	13.0	10.4
Бараа материал	166.1	188.9	22.8
Үндсэн хөрөнгө	15,227.6	16,938.1	1,710.5
Нийт хөрөнгө	15,433.5	17,161.6	1,728.1
Өр төлбөр	0.4	0.03	(0.4)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	15,433.1	17,161.6	1,728.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	15,433.5	17,161.6	1,728.1

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 21.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 15.6 сая төгрөгөөр буурсан байна.
- ✓ Авлага 10.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авиа компанийн хоорондын тооцооноос үүссэн барагдуулах бүрэн боломжтой.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 22.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан 22.6 сая төгрөгийн нүүрсний үлдэгдэл байна.
- ✓ Үндсэн хөрөнгө өмнөх оноос 1,710.5 сая төгрөгөөр нэмэгдсэн үүний гол шалтгаан нь анхны өртгөө нөхсөн хөрөнгийг ТӨБЗГ-ын шийдвэрээр ашиглах жилийг нэмэгдүүлэн дахин үнэлсэн, барилгын их засвар хийгдсэн, ИНЕГ-аас холбооны тоног төхөөрөмжийг шинэчлэн ирсэнтэй холбоотой нэмэгдсэн.
- ✓ Эзний өмчийн дансны хувьд тайлант онд 645.4 сая төгрөгийн ашигтай, дахин үнэлгээний данс 1,105.0 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

“Ховд” нисэх буудлын 2022 оны төсвийн төслийг дээд шатны байгууллагад 2,090.1 сая төгрөгийн зардал гаргахаар, буулт хөөрөлт, зорчигчийн үйличлгээний орлого, бусад орлогоос 40.0, улсын төсвөөс 2,050.1 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөн хүргүүлсэн байна.

Тайлант оны орлого, зардлын төлөвлөгөөг ИНЕГ-ын даргын тушаалаар 2,024.7 сая төгрөгөөр батлагдаж, 11 дүгээр сард 22.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төгрөгөөр нэмэгдүүлэн 2,047.2 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг дээд шатны байгууллагаас батлаагүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн гүйцэтгэлээр 2,545.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,899.7 сая төгрөгийн зардал гарган, 645.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,596.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 448.2 сая төгрөг буюу 21.9 хувиар дутуу бүрдүүлсэн нь улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн аваагүйтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,611.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 435.6 сая төгрөг буюу 21.3 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь улсын төсвөөс авсан санхүүжилтийн хүрээнд зардал гаргасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд аймгийн “Ховд” Нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 03 дугаар сарын 02-ноос 03 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 30 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,102.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 42.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 33.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1899.7 сая төгрөгөөр 2 хувиар буюу 38.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 30.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон үүний гол шалтгаан нь үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос буурсантай холбоотой байна.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус Ховд нисэх буудал нь холбогдох заалтуудыг мөрдөн ажилласан байна.

6 дугаар зүйлд заасан шатахууны зардалд тайлант онд 101.3 сая төгрөгийн төсөвтэй 102.7 сая төгрөгийн зардал гаргасан төсвийг 1.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь шатахууны үнийн өсөлттэй холбоотой, өмнөх онд 45342.6 литр, тайлант онд 31694 литр зарцуулж 13648.5 литр шатахуун хэмнэлт гарсан байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд 2022 онд 56.0 сая төгрөгийн томилолтын зардлыг батлагдаж, томилолтын зардалд 34.0 сая төгрөгийг зарцуулж 22.0 сая төгрөг, 11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 16.9 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр байгууллагын дотоод журмын дагуу 9.6 сая төгрөгийн зардал гарган 7.3 сая төгрөг, 12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн зүйл худалдан авах зардалд 161.3 сая төгрөг, гүйцэтгэлээр 98.1 сая төгрөгийн зардал гаргаж 63.2 сая төгрөг, 15 дугаар зүйлд заасан бусад хангамжийн материал, нормын хувцас худалдан авах зардлыг 20.8 сая төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 138 мэдээллийг хугацаандаа оруулсан 8 мэдээллийг хугацаа хоцроосон бусад мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж 91.7 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/сая. төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	11.1	3	11.1	100
Албан шаардлага	1	92.1	1	92.1	100
Зөвлөмж	4	214.1	3	214.1	75
Нийт дүн	8	317.3	7	317.3	91.7

Байгууллагын данс бүртгэлд байгаа орон сууцны асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй нь байгууллага, ажилтны хооронд хийгдсэн орон сууц ашиглах гэрээтэй, тухайн орон сууц ашиглагч нь өөрийн нэр дээр шилжүүлэн авах маргаантай асуудлаас шалтгаалан хэрэгжээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар ТӨБЗГ-ын шийдвэрээр анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлгээ хийгдсэнтэй холбоотой холбогдох дансны бичилт, 2022 оны 1-2 сард 36.7 сая төгрөгийн түлээ нүүрс, бусад материалын худалдан авалт, зарцуулалтын асуудлыг авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд залруулга хийх алдаа¹ илрээгүй болно.

Харин аудитаар нийт 18.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 16.6 сая төгрөгийн зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

ИНЕГ-ын даргын тушаалаар ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний сүлжээгээр олгох цалинг 1.5 сая төгрөгөөр илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," ИНЕГ-ын даргын 2020 оны А/34 тоот тушаалын 12 дугаар хавсралт "Орон нутгийн нисэх буудлуудын ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний хэмжээ" гэсэн заалтуудтай нийцээгүй "тохиолдсон байх", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан хаагчдад томилолтын мөнгө олгохдоо томилолтын хуудсыг бүрэн баталгаажуулаагүй 14.2 сая төгрөгийн зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гаргахгүй, холбогдох хуулийн заалтуудыг мөрдөн ажиллах

5.2.2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх онд өглөгөөр тусгаагүй хөдөлмөр хамгааллын хувцасны үнэ 2.4 сая төгрөгийг төлж тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, улирлын чанартай ажилчны нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог бүрэн оруулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь заалтуудыг мөрдөн ажиллах, шимтгэлийн тооцоог дахин тулган баталгаажуулах

5.2.3. Бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд зардлын зүйл ангийг зөрүүтэй сонгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах"; Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг холбогдох заавар журмын дагуу бэлтгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая. төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Үүнээс					
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан тушаалтны цалинг зөрүүтэй олгосон	1	1.5	1	1.5		

Томиллолтоор ажилласан албан хаагчдын томилолтын хуудсыг бүрэн баталгаажуулаагүй	1	14.2			1	14.2
Өмнөх онд өглөгөөр тусгаагүй хөдөлмөр хамгааллын хувцасны үнэ төлсөн	1	2.4			1	2.4
Мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд зардлын зүйл ангийг зөрүүтэй сонгосон	1	-			1	
Дүн	4	18.1	1	1.5	3	16.6

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 28/A2160424

Ховд

ХОА-2022/01/НА-СТА-ОНА
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Ховд" Нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланд аудитаар ИНЕГ-ын даргын тушаалаар ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний сүлжээгээр олгох цалинг илүү тооцон 1521.4 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", ИНЕГ-ын даргын 2020 оны А/34 тоот тушаалын 12 дугаар хавсралт "Орон нутгийн нисэх буудлуудын ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний хэмжээ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 1521376 /нэг сая таван зуун хорин нэгэн мянга гурван зуун далан зургаан төгрөг/-ийг төлүүлэн Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ховд Нисэх буудлын дарга Б.Болорцэцэг, нягтлан бодогч Д.Жимсээ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



У.БОЛДБААТАР

Д.НАРАНТУУЛ